



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦӨГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 02 өдөр

Дугаар

А/02

Амардалай

Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах тухай

Монгол улсын Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, Батлан хамгаалах сайдын 2017 оны А/322 тоот тушаалаар баталсан "Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. 2022 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Нарантунгалаг (ЗДТГ-ын дарга)

Гишүүдэд:

П.Амгаланбаатар (багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (багийн Засаг дарга)

Д.Ганчимэг (Татварын улсын байцаагч)

Хоёр. Бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 01 дүгээр сарын 25-ны дотор зохион байгуулан явуулсугай.

Гурав. Цэргийн тоо бүртгэлийн тайлан мэдээг 02 дугаар сарын 10-ны дотор аймгийн Цэргийн штабт хүргүүлэн ажиллахыг ЗДТГ-ын дарга (С.Нарантунгалаг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ



4880200458